



ИНД-157

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Аэродром байгуулах, өөрчлөх, нээх ба хаах тухай мэдэгдэл

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-157 нь, энэ Дүрэмд заасан төрлийн аэродром, эсхүл хэлипорт байгуулах, өөрчлөх, нээх эсхүл хаахыг санал болгож буй этгээдэд зориулсан журмыг тогтооно.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-157-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-157, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 02 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

Тэмдэглэл: ИНД-157-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 157 Amend.1-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

157.1	Хамрах хүрээ.....	5
157.3	Тодорхойлолт.....	5
157.5.	Мэдэгдэл шаардах төсөл	5
157.7	Зорилгын мэдэгдэл.....	6
157.9	Нисэхийн судалгаа	6
157.11	Аэродромын шийдвэр.....	7
157.13	Гүйцэтгэлийн мэдэгдэл.....	7

157.1 Хамрах хүрээ

(a) Энэ Дүрэм нь, энэ зүйлийн (b)-д заасан төрлийн аэродром, эсхүл хэлипорт байгуулах, өөрчлөх, нээх, эсхүл хаахыг санал болгож буй этгээдэд зориулсан журмыг тогтооно.

(b) Энэ Дүрэм нь дараах аэродром, эсхүл хэлипортод хамаарахгүй:

- (1) ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн байхыг шаарддаг аэродром; эсхүл
- (2) аливаа дараалсан 30 хоногт 7-оос дээшгүй хоног ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөсөн, ил харааны хэрэглэлийн нислэгийн дүрэм (цаашид ИХНД/VFR гэх)-ээр үйл ажиллагаа нь хязгаарлагддаг аэродром, эсхүл хэлипорт; эсхүл
- (3) зөвхөн хөдөө аж ахуйн (цаашид ХАА гэх) агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөсөн, нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй, дараах аэродром:
 - (i) хамгийн ойрын бусад аэродромоос 9 км (5 nm)-ээс багагүй зайд байрладаг;
 - (ii) хамгийн ойрын хэлипортоос 5.6 км (3 nm)-ээс багагүй зайд байрладаг; эсхүл
- (4) зөвхөн ХАА-н нисдэг тэрэг ашигладаг, эсхүл ашиглахаар зориулагдсан, нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй, дараах хэлипорт:
 - (i) хамгийн ойрын аэродромоос 6 км (3 nm)-ээс багагүй зайд байрладаг;
 - (ii) хамгийн ойрын бусад хэлипортоос 1.8 км (1 nm)-ээс багагүй зайд байрладаг.

157.3 Тодорхойлолт

Энэ Дүрмийн 157.1 болон 157.5-ын тухайн зорилгоор:

“**Аэродром**” нь, нисдэг тэрэг ашиглахад тусгайлан зориулсан, эсхүл бүтээсэн, газар, эсхүл усан дээр тогтоосон талбайг багтаахгүй;

“**Хэлипорт**” гэж нисдэг тэрэг ашиглахад газар, эсхүл усан дээр тусгайлан зориулсан, эсхүл бүтээсэн болон байгууламж дээр тогтоосон аливаа талбайг.

157.5. Мэдэгдэл шаардах төсөл

Дараах аливаа ажлыг гүйцэтгэхээр зорьж буй этгээд (цаашид Хүсэлт гаргагч гэх) нь 157.7-д заасан хэлбэрээр Даргад мэдэгдэнэ:

- (1) энэ Дүрэмд хамаарах аэродром, эсхүл хэлипортыг байгуулах, эсхүл бусад хэлбэрээр бий болгох, эсхүл ийм аэродром, эсхүл хэлипортыг нээх;
- (2) энэ Дүрэмд хамаарах аэродром, эсхүл хэлипортын аливаа хөөрч буух зурвас, эсхүл бусад агаарын хөлгийн хөөрөлт, эсхүл буултын талбайг байгуулах, чиглэл өөрчлөх, хаах, эсхүл нээх;

- (3) зөвхөн ИХНД/VFR-ээр үйл ажиллагаа нь хязгаарлагддаг аэродром, эсхүл хэлипортыг дараалсан 30 хоногт 7-оос дээш олон хоногоор ашиглахаар сунгах;
- (4) энэ Дүрэмд хамаарах аэродром, эсхүл хэлипорт, эсхүл ийм аэродром, эсхүл хэлипортын хөөрөлт, эсхүл буултын аливаа талбайг нэг жил, эсхүл түүнээс дээш хугацаагаар хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзах.

157.7 Зорилгын мэдэгдэл

- (a) Энэ дүрмийн 157.5 (1), (2) болон (3)-т шаардсан мэдэгдлийг, тухайн ажил эхлэх өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө САА 24157/01 маягтын дагуу Даргад хүргүүлсэн байна.
- (b) Энэ дүрмийн 157.5(4)-т шаардсан мэдэгдлийг, хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзахаар төлөвлөсөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр хүргүүлсэн байна.

157.9 Нисэхийн судалгаа

- (a) Дарга, 157.7(a)-ийн дагуу мэдэгдэл хүлээн аваад нисэхийн судалгаа хийнэ.
- (b) Дарга тухайн нисэхийн судалгаа хийхдээ хамааралтай гэж үзсэн иргэд, төлөөллийн бүлэг болон байгууллагатай зөвлөлдөнө.
- (c) Нисэхийн судалгааг, тухайн санал болгож буй ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах, болон газар дээрх хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдал үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор хийнэ. Тухайлбал, нисэхийн судалгаа нь дараах хүчин зүйлийг анхаарч авч үзнэ:
 - (1) санал болгож буй ажиллагаа, одоогийн, эсхүл шинээр төлөвлөж байгаа аэродром, хөрш аэродромын нислэгийн хөдөлгөөний нягтралд хэрхэн нөлөөлөх;
 - (2) санал болгож буй ажиллагаа, ашиглаж байгаа болон төлөвлөж байгаа агаарын зайд хэрхэн нөлөөлөх;
 - (3) санал болгож буй ажиллагаа, хүмүүс болон газар дээрх өмч хөрөнгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх;
 - (4) тухайн холбогдох газар нутагт байгаа хүн бүтээсэн, эсхүл хүн бүтээхээр санал болгосон объект болон байгалийн объект нь санал болгож буй ажиллагаанд хэрхэн нөлөөлөх.

157.11 Аэродромын шийдвэр

(a) Нисэхийн судалгаа дууссаны дараа Дарга хүсэлт гаргагч, холбогдох орон нутгийн удирдлага болон бусад сонирхогч этгээдэд дараах аль нэг аэродромын шийдвэрийг гаргана:

- (1) **Татгалзах зүйлгүй:** Санал болгож буй ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах, болон газар дээрх хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга татгалзаагүй гэсэн шийдвэр гаргана;
- (2) **Нөхцөл заасан:** Дарга, санал болгож буй ажиллагааны хүлээн авах боломжгүй хүчин зүйлийг тогтоон, хэрэв тодорхой заасан нөхцөлийг дагаж мөрдсөн тохиолдолд тухайн санал болгож буй ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах, газар дээрх хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй гэж Дарга үзвэл нөхцөл заасан шийдвэр гаргана;
- (3) **Хүлээн авах боломжгүй:** Дарга санал болгож буй ажиллагааг хүлээн авах боломжгүй шалтгааныг тогтоовол, хүлээн авах боломжгүй шийдвэр гаргах ба санал болгож буй ажиллагааг хүлээн авах боломжгүй болсон Даргын шалтгааныг тодорхой заана.

(b) Нислэг үйлдэх агаарын зайн ашиглалтын оновчтой төлөвлөлтийг хялбаршуулах зорилгоор хүлээн авах боломжгүй зүйлгүй болон нөхцөл заасан шийдвэрт тухайн хүчингүй болох хугацааг тодорхой заана.

(c) Энэ Дүрэмд шаардсан мэдэгдэл шаардлагатай бүх ажил, эсхүл ажиллагааг тухайн шийдвэрт заасан хугацаанд багтаан хэрэгжүүлж дууссан байна. Сунгасан, шинэчилсэн, эсхүл цуцалснаас бусад тохиолдолд, аэродромын шийдвэр нь заагдсан тухайн өдөртөө хүчингүй болно.

(d) Сонирхогч этгээд нь шийдвэрийн хүчингүй болох хугацаанаас 15-аас доошгүй хоногийн өмнө Даргад дараах хүсэлтийг гаргаж болно:

- (1) тухайн шийдвэр гарсан үндэслэлийг өөрчлөх шинэ баримтад тулгуурлан шийдвэрийг дахин авч үзэх; эсхүл
- (2) шийдвэрийн үйлчлэх хугацааг сунгах.

157.13 Гүйцэтгэлийн мэдэгдэл

Хүсэлт гаргагч нь 157.5-ын дагуу аливаа хийгдсэн ажлын гүйцэтгэлийн талаар, тухайн ажиллагаа дууссанаас хойш 15 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.

--oOo--